

ХИЧЭЭЛ-7

Хичээл анги: 12 анги

Агуулгын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг:

Материаллаг чанар агаар орон зай гаргасан натюрморт

Хичээлийн заах цаг: 9 цаг

Заах сэдэв: Сонгодог барималтай эд хогшилтой натюрморт


Хүлээгдэж буй үр дүн:

Сонгодог баримлын анатоми эд зүйлсийн цогцлолыг дулаан хүйтэн өнгийн хослолоор орон зайг илэрхийлж олон дүрст натюрмортыг өнгөөр бичиж мэргэжлийн онцлогт тохируулж зурах

Агуулга:

Сонгодог баримлын анатоми эд зүйлсийг үнэн зөв зурах, өөрийн дотоод сэтгэлийн илэрхийллийг гарган өнгөөр бичиж мэргэжлийн онцлогтой зурах

Арга зүй: Сонгодог баримал дулаан хүйтэн өнгийн даавуу 5-7 дүрстэй байна.





Үнэлгээний бүрдэл:

Нийт 100 оноо

-Зохиомж авалт 30 оноо

-Техник ажиллагаа 30 оноо

-Гүйцэтгэл 40 оноо

-Зохиомж тэнцвэртэй, тэнцвэргүй авснаас нь шалтгаалан 0-30 хүртэлх оноо

-Тухайн сонгосон материалын техник ажиллагааг эзэмшсэн болон материаллаг шинж чанарын онцлогийг хэрхэн гаргаж байгаагаас хамааран 0-30 хүртэлх оноо

Натюрмортын гүйцэтгэлийн бүрэн дуусгаснаас хамааран 0-30 хүртэлх оноог тус тус өгнө

Гэрийн даалгавар:

Сэдэв: Нэгж хичээлийн сэдвийн дагуу хуулбар хийх

Тоо ширхэг: Натюрморт оролтын хугацаанаас хамааран 4-5 ширхэг

Хэмжээ: А2, А3, А4 мөн чөлөөт

Техник: Усан будаг, гуаш, цэрдэн харандаа

